



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР**

Засгийн газрын XII байрны баруун жигүүр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 36 28, Факс: (976-11) 31 03 70,
Цахим шуудан: info@mrpm.gov.mn,
Цахим хуудас: mrpm.gov.mn

2026.06.10 № 1/3431

танай _____-ны № _____-т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 10 дугаар албан даалгавар гарч, хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд батлан хэрэгжүүлж байна.

Үүний дагуу Ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан Байгаль орчныг хамгаалах талаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хүлээх үүрэг, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг биелүүлэн ажиллах, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан тооцож, аливаа ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг та бүхэнд мэдэгдэж байна.

Мөн, тусгай зөвшөөрлийн талбайн хэмжээнд үзлэг хийж, нөхөн сэргээгдээгүй цооног, суваг, малталтууд байгаа эсэхийг шалган нөхөн сэргээж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрхэн биелүүлэн ажиллаж буй талаарх мэдээ тайланг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

П.БАЯНБААТАР



1526407216